



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН НЭР: СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ,
ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

АУДИТЫН КОД: /ӨМА-2020/05/-ГА



**СОНГУУЛИЙН ЗАРДЛЫГ АРВИЛАН ХЭМНЭЛТТЭЙ
ЗАРЦУУЛСАН БАЙНА**

2020 он

Аудитыг гүйцэтгэсэн:	Агуулга	Хуудас
Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Хонгорзул Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежерын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Одончимэг Ахлах аудитор: Г.Шижирболд Аудитор Т.Хишигбат	Товчилсон үгийн тайлбар	3
	Хүснэгт, график, дүрслэл, бүдүүвчийн жагсаалт	4
	Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	5-6
	Бүлэг 1. Аймаг, сумдын ИТХ-н 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж хуваарилсан байна.	7-9
	Бүлэг 2. Аймаг, сумдын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан байна.	10-14
	Дүгнэлт	15
	Тэргүүлэх аудиторын тушаал	16
2020 оны 11 дүгээр сар		
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70533539, 70533552 дугаарын утсаар харилцана уу.		
Тайланг ӨМТАГ-ын www.umnugovi@audit.gov.mn цахим хуудаснаас үзнэ үү.		
Хаяг: Нутгийн удирдлагын ордон, 3 давхар, 303 тоот4.		

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СЕХ	Сонгуулийн Ерөнхий Хороо
СХ	Сонгуулийн хороо
АСХ	Аймгийн Сонгуулийн хороо
ССХ	Сумын Сонгуулийн хороо
ХХ	Хэсгийн хороо
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МТБ	Мэдээлэл технологийн баг
УИХСХ	Улсын Их Хурлын Сонгуулийн Хороо

Хүснэгт, график, дүрслэл, бүдүүвчийн жагсаалт

Хүснэгт-1 Аймгийн СХ-оос аймаг, сумдын сонгуулийн хороонд батлагдсан төсөв

Хүснэгт-2 Аймгийн СХ-оос Аймаг, сумдын сонгуулийн хороонд батлагдсан төсөв зардал тус бүрээр

Хүснэгт-3 Аймаг, сумдын ИТХ-н 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны хэмнэлтийг зардал тус бүрээр

Хүснэгт-4 Аймаг, сумдын ИТХ-н 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлийг зардал тус бүрээр

Хүснэгт-5 Аймаг, сумдын ИТХ-н 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлийг сум тус бүрээр

График-1 Аймаг, сумдын ИТХ-н 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах үйл ажиллагааны зардлын санхүүжилт

График-2 Аймаг, сумдын ИТХ-н 2016 он, 2020 оны ээлжит сонгуулийн батлагдсан төсвийн харьцуулалт

График-3 Аймаг, сумдын ИТХ-н 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны зардлын хэмнэлт

График-4 Аймаг, сумдын ИТХ-н 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны зардлын хэмнэлтийг аймаг, сумдаар харуулбал

График-5 Аймаг, сумдын ИТХ-н 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэл

Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийх Үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 04 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл”-д Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан УИХ, Засгийн газар, холбогдох байгууллагад танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитын дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:

- Орон нутгийн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх
- Орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймаг, сумын сонгуулийн хороо, хэсгийн хороодыг хамруулна

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Гүйцэтгэлийн аудит MNS 6817-7:2020, Нийцлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулав. Аудитын хөтөлбөрийг орон нутгийн онцлогт тохируулан боловсруулав.

Аудитад ашигласан шалгуур:

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль

**Аудит хийсэн
багийн
бүрэлдэхүүн**

- Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль
- Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль
- Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, журам

**Аудитын
хугацаа**

Аудитыг газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Хонгорзул удирдаж, үе шатны хяналтыг хэлтсийн дарга бөгөөд аудитын менежерийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Одончимэг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Шижирболд, аудитор Т.Хишигбат нар гүйцэтгэв.

Аудитыг 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл хугацаанд хэрэгжүүлэв.

БҮЛЭГ 1

Улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж хуваарилсан байна.

1.1 Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодиттой тооцож олгосон байна.




Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай” журмын дагуу аймаг, сумдын сонгуулийн хороо, салбар комисст зардлыг тооцож олгосон байна.

Аймаг, сумдын ИТХ-н 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах үйл ажиллагааны зардлын санхүүжилт:

/График-1/

/сая.төгрөг/




Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-н 2020 оны ээлжит сонгуулийн хорооны 2020 оны тайлан

Аймаг, сумдын ИТХ-н 2020 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагааны зардал нь батлагдсан төсвийн дагуу санхүүжүүлэгдсэн байна.

Аймаг, сумдын ИТХ-н 2016 он, 2020 оны ээлжит сонгуулийн батлагдсан төсвийн харьцуулалт:

/График-2/

/сая.төгрөг/



Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-н 2020 оны ээлжит сонгуулийн хорооны 2020 оны тайлан

Аймаг, сумдын ИТХ-н 2020 оны батлагдсан төсөв нь өмнөх удаагийн ээлжит сонгууль буюу 2016 онтой харьцуулахад 48.5 сая төгрөгөөр өссөн байна.

1.2 Сонгуулийн хороодод зардлын төсвийг үндэслэлтэй тооцож хуваарилсан байна.



Аймгийн сонгуулийн хороо нь Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай” журам, СЕХ-оос өгсөн албан бичиг, заавар, зөвлөмжийн дагуу аймаг, сумдын сонгуулийн хороодын зардлыг тооцож хуваарилсан байна.

Аймгийн СХ-оос аймаг, сумдын сонгуулийн хороонд батлагдсан төсвийг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт-1/

/сая төгрөг/

№	СУМДЫН НЭРС	БАТЛАГДСАН ТӨСӨВ
1	Баяндалай сумын СХ	14.3
2	Баян-Овоо сумын СХ	14.5
3	Булган сумын СХ	18.9
4	Гурвантэс сумын СХ	21.9
5	Даланзадгад сумын СХ	38.8
6	Мандал-Овоо сумын СХ	14.6
7	Манлай сумын СХ	18.1
8	Ноён сумын СХ	10.9
9	Номгон сумын СХ	22.3
10	Сэврэй сумын СХ	15.6
11	Ханбогд сумын СХ	21.7
12	Ханхонгор сумын СХ	18.1
13	Хүрмэн сумын СХ	14.1
14	Цогт-Овоо сумын СХ	14.5
15	Цогтцэций сумын СХ	17.7
16	Өмнөговь аймгийн СХ	54.6
НИЙТ		330.6

Эх сурвалж: Аймгийн Сонгуулийн хорооны 2020 оны тайлан

Аймгийн СХ нь СЕХ-ны Ажлын албаны 2020 оны 08 сарын 26-ны өдрийн 3/396 тоот, 2020 оны 09 сарын 14-ны өдрийн 3/430 тоот, 2020 оны 09 сарын 28-ны өдрийн

3/450 тоот, 2020 оны 10 сарын 07-ны өдрийн 3/465 тоот бичгээр өгсөн заавар зөвлөмжийн дагуу тус тус хуваарилсан байна.

**Аймгийн СХ-оос Аймаг, сумдын сонгуулийн хороонд батлагдсан
төсвийг зардлаар нь харуулбал:**

<i>/Хүснэгт-2/</i>		<i>/сая төгрөг/</i>
№	Зардлын нэр	Батлагдсан төсөв
1	Тогтоол, протокол, бусад мягт хэвлүүлэх	0.3
2	Үнэмлэх хэвлэх зардал	2.3
3	Сургалтын зардал	12.5
4	Бичиг хэргийн зардал	7.9
5	Шуудан холбооны зардал	9.3
6	Унааны зардал	34.1
7	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	13.4
8	Сурталчилгааны зардал	8.0
9	Саналын хуудас, ICP төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх зардал	19.8
10	МТБ-ийн зардал	0.7
11	Сонгуулийн автоматжуулсан системийн зардал /эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх/	2.1
12	Томилолтын зардал	7.6
13	Унааны зардал /Туршилтын болон санал авах өдрийн мэдээ дамжуулах/	2.1
14	Болзошгүй зардал	6.2
15	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	177.0
16	МТТ-ийн багийн гишүүн, санал авах байрны даамлын урамшуулал, хоолны зардал	27.3
НИЙТ		330.6

Эх сурвалж: Аймгийн Сонгуулийн хорооны 2020 оны тайлан

Аймгийн СХ болон сумдын СХ нь батлагдсан төсвийн хүрээнд зардал тус бүрд нь СЕХ-оос өгсөн албан тоот болон Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай” журмын дагуу тооцож хуваарилсан байна.

БҮЛЭГ 2

Улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хэмнэлттэй зарцуулсан байна.

2.1 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулсан байна.




Аймаг, сумдын ИТХ-н 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахад 330.6 сая төгрөг батлагдаж 321.8 сая төгрөг зарцуулж 8.8 сая төгрөг хэмнэж СЕХ-нд төвлөрүүлж ажилласан байна.

Аймаг, сумдын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны зардлын хэмнэлтийг хүснэгтээр харуулбал:

/График-3/

/сая төгрөг/




Эх сурвалж: Аймгийн Сонгуулийн хорооны 2020 оны тайлан

Дээрх хүснэгтээс харахад аймаг, сумдын ИТХ-н 2020 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагааны зардлыг аймгийн СХ 5.1 сая төгрөг, сумдын СХ 3.7 сая төгрөгийг тус тус хэмнэж ажилласан байна.

Аймаг, сумдын ИТХ-н 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны зардлын хэмнэлтийг аймаг, сумдаар харуулбал:

/График-4/

/сая төгрөг/



Аймаг, сумдын ИТХ-н 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахад Булган сумын СХ 1.1 сая, Мандал-Овоо сумын СХ 1.4 сая, Цогтцэций сумын СХ 1.2 сая төгрөгийг тус тус хэмнэсэн бол аймгийн СХ 5.1 сая төгрөгийг хэмнэж ажилласан байна.

Аймаг, сумдын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны хэмнэлт гарсан зардлууд:

/Хүснэгт-3/

/сая төгрөг/

№	Зардлын нэр	Төсвийн хэмнэлт
1	Сургалтын зардал	2.2
2	Шуудан холбооны зардал	0.3
3	Унааны зардал	2.5
4	Сурталчилгааны зардал	0.2
5	Саналын хуудас ICP төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх зардал	1.7
6	Томилолтын зардал	0.6
7	Унааны зардал /туршилтын болон санал авах өдрийн мэдээ дамжуулах/	0.2
8	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны гишүүний урамшуулал хоолны, зардал	1.2
НИЙТ		8.8

Эх сурвалж: Аймгийн Сонгуулийн хорооны 2020 оны тайлангаас

Дээрх хүснэгтээс харахад 8 төрлийн зардлыг хэмнэгдэж 8.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Мөн унааны зардал 2.5 сая төгрөг, сургалтын зардал 2.3 сая төгрөгийг тус тус хэмнэгдсэн байна.

2.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.




Аймаг, сумдын ИТХ-н 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахад аймаг, сумдын сонгуулийн хороонд 330.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 321.8 сая төгрөгийг зарцуулж 97.3%-ийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аймаг, сумдын ИТХ-н 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэл:

/График-5/

/сая төгрөг/



Эх сурвалж: Аймгийн Сонгуулийн хорооны 2020 оны тайлан

Дээрх графикаас харахад аймгийн хэмжээнд аймаг, сумдын ИТХ-н 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахад аймгийн СХ 49.4 сая төгрөг, сумдын СХ 272.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Аймаг, сумдын ИТХ-н 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлийг зардлаар нь харуулбал:

/Хүснэгт-4/

/сая төгрөг/

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл
1	Тогтоол, протокол, бусад мягт хэвлүүлэх	0.3	0.3
2	Үнэмлэх хэвлэх зардал	2.3	2.3
3	Сургалтын зардал	12.5	10.3
4	Бичиг хэргийн зардал	7.9	7.9
5	Шуудан холбооны зардал	9.3	9.1
6	Унааны зардал	34.1	31.5
7	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	13.4	13.4
8	Сурталчилгааны зардал	8.0	7.9
9	Саналын хуудас, ICP төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх зардал	19.8	18.1
10	МТБ-ийн зардал	0.7	0.7
11	Сонгуулийн автоматжуулсан системийн зардал /эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх/	2.1	2.1
12	Томилолтын зардал	7.6	7.0
13	Унааны зардал /Туршилтын болон санал авах өдрийн мэдээ дамжуулах/	2.1	2.0
14	Болзошгүй зардал	6.2	6.2
15	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	177.0	175.8
16	МТТ-ийн багийн гишүүн, санал авах байрны даамлын урамшуулал, хоолны зардал	27.3	27.3
НИЙТ		330.6	321.8

Эх сурвалж: Аймгийн Сонгуулийн хорооны 2020 оны тайлан

Аймаг, сумдын СХ-д 330.6 сая төгрөгийн батлагдсан төсвөөс 321.8 сая төгрөгийн зарцуулж 16 төрлийн зардлаас 8 зардлыг гүйцэтгэл хэмнэлттэй гарсан байна.

**Аймаг, сумдын ИТХ-н 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл
ажиллагааны төсвийн гүйцэтгэлийг сумдаар харуулбал:**

/Хүснэгт-5/

/сая төгрөг/

№	Сумдын нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн хэмнэлт
1	Баяндалай сумын СХ	14.3	14.3	-
2	Баян-Овоо сумын СХ	14.5	14.5	-
3	Булган сумын СХ	18.9	17.8	1.1
4	Гурвантэс сумын СХ	21.9	21.9	-
5	Даланзадгад сумын СХ	38.8	38.8	-
6	Мандал-Овоо сумын СХ	14.6	13.2	1.4
7	Манлай сумын СХ	18.1	18.1	-
8	Ноён сумын СХ	10.9	10.9	-
9	Номгон сумын СХ	22.3	22.3	-
10	Сэврэй сумын СХ	15.6	15.6	-
11	Ханбогд сумын СХ	21.7	21.7	-
12	Ханхонгор сумын СХ	18.1	18.1	-
13	Хүрмэн сумын СХ	14.1	14.1	-
14	Цогт-Овоо сумын СХ	14.5	14.5	-
15	Цогтцэций сумын СХ	17.7	16.5	1.2
16	Аймгийн СХ	54.6	49.4	5.1
НИЙТ		330.6	321.8	8.8

Эх сурвалж: Аймгийн Сонгуулийн хорооны 2020 оны тайлан

Аймаг, сумдын ИТХ-н 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах үйл ажиллагааны зардлыг гүйцэтгэлийг Аймгийн СХ нь аймаг, сумдын СХ-д үнэн зөв бүрэн гүйцэт мэдээллэн, санхүүгийн тайланг аймгийн СХ-д хүргүүлсэн байна.

2.3 Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт сул байна.

Аймгийн СХ нь аймаг, сумын ИТХ-н 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлийн гүйлгээ хийж буй нягтлан бодогч, зарцуулалтын гүйлгээг хийж, гүйцэтгэж, баталгаажуулж байгаа төрийн сангийн мэргэжилтнүүдийн анхан шатны баримтын бүрдэлд дээр тавих хяналт сул байна. Тухайлбал:



Баяндалай сумын СХ нь албан томилолтын зардлаас 0.2 сая төгрөгийн гүйлгээг анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад хийж гүйцэтгэсэн байна.



Баян-Овоо сумын СХ нь албан томилолтын зардлаас 0.2 сая төгрөгийн гүйлгээг анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад хийж гүйцэтгэсэн байна.



Булган сумын СХ нь албан томилолтын зардлаас 0.2 сая төгрөгийн гүйлгээг анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад хийж гүйцэтгэсэн байна.



Гурвантэс сумын СХ нь албан томилолтын зардлаас 0.2 сая төгрөгийн гүйлгээг анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад хийж гүйцэтгэсэн байна.



Сэврэй сумын СХ нь албан томилолтын зардлаас 0.1 сая төгрөгийн гүйлгээг анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад хийж гүйцэтгэсэн байна.



Цогтцэций сумын СХ нь албан томилолтын зардлаас 0.1 сая төгрөгийн гүйлгээг анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад хийж гүйцэтгэсэн байна.

Дээрх алдаа зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” дахь заалттай нийцэхгүй байна. Аймаг, сумдын СХ-ын зардлын гүйцэтгэлийн тайланг нягталж, тулган баталгаажуулалт хийж хүлээн авбал дээрх 1.0 сая төгрөгийн алдаа зөрчлыг арилгах бүрэн боломжтой байна.

ДҮГНЭЛТ

Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд хийсэн аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- ✓ СЕХ нь Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай” журмын дагуу аймаг, сумын ИТХ-ын сонгуулийн зардлыг тооцож олгосон байна.
- ✓ Аймгийн сонгуулийн хороо нь Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай” журам, СЕХ-оос өгсөн албан бичиг, заавар, зөвлөмжийн дагуу аймаг, сумдын сонгуулийн хороодын зардлыг тооцож хуваарилсан байна.
- ✓ Аймаг, сумдын ИТХ-н 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахад 330.6 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 321.8 сая төгрөг зарцуулж 8.8 сая төгрөгийг хэмнэж СЕХ-нд төвлөрүүлж ажилласан байна.
- ✓ Аймгийн СХ нь аймаг, сумын ИТХ-н 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны зардлын гүйлгээ хийж буй нягтлан бодогч, тухайн гүйлгээг хийж, баталгаажуулж байгаа төрийн сангийн мэргэжилтнүүдийн анхан шатны баримтын бүрдэл дээр тавих хяналт зарим сумдад хангалтгүй байна.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2020 оны 11 сарын 13 өдөр

Дугаар A/35

Даланзадгад

┌ Аудитын тайлан баталгаажуулах ┐
тухай

“Төрийн аудитын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 9 дүгээр зүйл, Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2018 оны A/207 дугаар тушаалын тавдугаар хавсралтын 1.3 дахь заалт, 2016 оны A/92 тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын журам” –ын 12.40 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл” –д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг ҮАГ-ийн Гүйцэтгэлийн аудитын газарт хүргүүлсүгэй.

3. Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд түгээхийг нийцлийн аудитын баг /Т.Хишигбат/-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ХОНГОРЗУЛ

D:\Бичиг Хэрэг\А Тушаал 2020\A-35.Docx

016010013